



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Чингисийн өргөн чөлөө 45, 3 дугаар хороо,

Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060

Утас: 34 16 74, Факс: (976-11) 34 30 61,

Цахим шуудан: info@ubedn.mn, Цахим хуудас: www.tog.mn

2024-02-08 № 1/237
таний -ны № -т

Г Тодруулгын хариу хүргүүлэх Г

Тодруулгын хариу хүргүүлэх
тухай

Тодруулга 1:

ТШЗ 17.1-д заасан Тендерт оролцогчийн ирүүлсэн татварын тодорхойлолтод илүү төлөлттэй татварын дүн, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй гэсэн байгаа нь илүү төлөлттэй байж болохгүй гэсэн үг үү.

Хариулт:

Тендер нээсэн өдрийн байдлаар цахим системээр дамжуулан лавлагааг татаж үзэх ба Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. Тодорхойлолтод татвар, хураамжийн илүү төлөлттэй тохиолдолд давуу эрх болохгүй.

Тодруулга 2:

Тендэрийн шаардлагын 2.33 Дагалдах хэрэгсэл хэсэгт 1000 ширхэг тоолуур тутамд 1 ширхэг тоолуур удирдах зөөврийн гар удирдлагын багаж дагалдана, III БҮЛЭГ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА Техникийн тодорхойлолт хэсгийн 1.18-д Нийлүүлэгдэх тоолуурын програм хангамжийг захиалагч талын шаардлагын дагуу үйлдвэрт нь програмчлан нийлүүлэх ба тоолуур програмчлах лабораторийн түвшиний програм хангамжийг хүлээлгэн өгнө. Мөн тоолуур програмчлах гар удирдлагатай зөөврийн багаж (ННУ)-ийг 10000 ухаалаг тоолуур тутамд 1ш-ээр тооцож нийлүүлэх гэж заасан байна. Энэ 2 заалтад тусгагдсан гар удирдлага нь ижил төхөөрөмж үү? Хэрэв ижил бол аль тоо нь зөв бэ?

Хариулт:

Тоолуур удирдах, программчлах зориулалт бүхий гар удирдлагатай зөөврийн багаж нь Техникийн шаардлагын 1.18-д заасны дагуу 10000 ш тоолуур тутамд 1 ш байхаар тооцож ирүүлнэ.

Тодруулга 3:

Танай байгууллагаас зарласан “Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төсөл” УБЦТС/202311215 дугаартай, 71,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа нийлүүлэх тендер шалгаруулалтын ТӨХ-ийн ТШЗ 2.1-д Санхүүжилтийн эх

үүсвэрийг “Өөрийн хөрөнгө” гэж заасан байна. Мөн ГЕН 3.9-д “...Бараа материалыг бүрэн хүлээн авч, гэрээ дүгнэсэн протокол үйлдсэн тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 30 хувь, 2024 оны 07 дугаар сард гэрээний үнийн дүнгийн 15 хувь, 2024 оны 12 дугаар сард гэрээний үнийн дүнгийн 15 хувь төлнө” гэж заажээ. Өөрөөр хэлбэл 2024 онд захиалагчийн санхүүжүүлэх дүн нь нийт төсөвт өргтийн 60 хувь буюу 21,6 тэрбум төгрөг байх юм байна. Шилэн данс (<https://shilendans.gov.mn>) –д байршуулсан УБЦТС ТӨХК-ийн 2024 оны батлагдсан төсөвт энэхүү төслийн санхүүжилт болох 21,6 тэрбум төгрөг тусгагдаагүй байна. Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 9.1.15-д Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын “....хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх” нь ЭХЗХ-ны бүрэн эрх байна гэж заасан байна. Иймд энэхүү төслийг хэрхэн санхүүжүүлэх талаар эрх бүхий байгууллага болох ЭХЗХ-ны шийдвэрийг тендерт оролцогчидод ирүүлнэ үү. Тендерт оролцохоор бэлдэж буй байгууллагын хувьд төслийн санхүүжилтүүн эх үүсвэр хэрхэн шийдвэгдэж байгаа нь туйлын чухал байна.

Хариулт:

Тус компанийн цахилгаан түгээх, хангах тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо баталдаг бөгөөд Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төслийн эхний шатны хөрөнгө оруулалтад шаардлагатай 14.5 тэрбум төгрөгийг ЭХЗХ-ны 2023 оны 643 дугаар тогтоолоор 2023 оны цахилгаан түгээх, хангах тарифт тусгаж баталсан.

Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төслийн 2024 оны санхүүжилтэд шаардлагатай 12.6 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг ЭХЗХ-ны 2024 оны 112 дугаар тогтоолоор тус компанийн 2024 оны цахилгаан түгээх, хангах тарифт тусгаж баталсан болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН